



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/19/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 261628 Цахим хаяг: munkhtsatsrall@audit.gov.mn
Аудитор: Ц.Мөнхтуяа
Утас: 261740 Цахим хаяг: Munkhtuyats@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө	11
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны мэдээлэл	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Харьяа байгууллагууд.....	17
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	17
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа.....	17
4.2.2 Албан шаардлага	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮДАГ	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
МЭЭСБУЛ	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори
УМЭАЦТ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.БАТЧУЛУУН ТАНАА

᠘᠐᠒᠒.03.25 № 01/710
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа 25 нэгжийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 2,341.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,883,999.7	10,914,836.8
31	Мөнгөн хөрөнгө	-	0.1
33	Авлага	811,816.2	1,135,458.0
34	Урьдчилгаа	83,808.4	179,150.0
35	Бараа материал	10,988,375.0	9,600,228.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	26,324,447.4	26,493,375.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,324,447.4	26,493,375.8
39200	Биет хөрөнгө	24,170,110.2	24,048,201.7
39300	Биет бус хөрөнгө	2,154,337.2	2,445,174.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	38,208,447.2	37,408,212.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,692,256.4	53,879.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,692,256.4	53,879.2
41300	Өглөг	1,692,256.4	53,879.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	36,516,190.7	37,354,333.4
51	Засгийн газрын хувь оролцоо	36,516,190.7	37,354,333.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,281,790.5	9,348,990.5
51200	Хуримтлагдсан үр дүн	23,122,784.7	23,893,727.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,111,615.5	4,111,615.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	38,208,447.2	37,408,212.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	62,774,778.3	60,797,458.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,555,727.4	4,906,598.3
120	Нийтлэг татварын бус орлого	9,555,727.4	4,906,598.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	53,219,051.0	55,890,859.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	60,916,974.0	60,105,683.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,916,974.0	60,105,683.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,261,431.8	58,046,699.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,158,162.7	12,646,381.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	847,955.8	1,724,339.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	590,790.2	608,509.6
2104	Хангамж, бараа материалын зардал	1,525,702.6	2,202,641.3
2105	Нормативт зардал	22,858,728.5	20,193,018.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	361,706.6	383,667.9
2107	Томилолт, зочны зардал	267,127.1	367,253.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,319,750.3	13,647,861.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,331,507.9	6,273,026.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,655,542.2	2,058,984.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,857,804.4	691,774.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	148,215.8	2,683.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,709,588.5	689,091.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	57,745,568.1	57,266,022.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	867,311.2	921,814.1
120	Нийтлэг татварын бус орлого	867,311.2	921,814.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56,878,256.9	56,344,208.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,997,665.0	56,716,595.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,997,665.0	56,716,595.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,723,180.6	54,580,494.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,728,216.9	12,660,882.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	621,017.5	1,715,136.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	592,823.6	634,432.6
2104	Хангамж, бараа материалын зардал	893,656.7	810,082.2
2105	Нормативт зардал	13,905,955.9	20,048,131.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,017,534.3	618,913.4
2107	Томилолт, зочны зардал	259,068.3	366,192.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,194,847.0	16,669,650.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,510,060.4	1,057,073.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,274,484.4	2,136,101.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,747,903.1	549,426.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,748,163.6	549,426.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,748,163.6	549,426.6
2200	Дотоод эх үүсвэрээр	3,748,163.6	549,426.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,748,163.6)	(549,426.6)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(260.5)	0.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	260.5	0
102	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,805,960.2		34,805,960.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	30,503.4		30,503.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,836,463.6		34,836,463.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-29,861.4		-29,861.4
9	Тайлант үеийн үр дүн	1,709,588.5		1,709,588.5
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,516,190.7		36,516,190.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	81,851.5		81,851.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,598,042.2		36,598,042.2
17	Өмчид гарсан өөрчлөлт	67,200.0		67,200.0
19	Тайлант үеийн үр дүн	689,091.2		689,091.2
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,354,333.4		37,354,333.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,903,981,500.00	44,346,010,469.19	1,557,971,030.81	96.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,903,981,500.00	44,346,010,469.19	1,557,971,030.81	96.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,286,734,700.00	43,828,163,777.59	1,458,570,922.41	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,791,401,400.00	12,640,642,389.80	1,150,759,010.20	91.7
210101	Үндсэн цалин	9,994,858,400.00	9,310,087,624.55	684,770,775.45	93.1
210102	Нэмэгдэл	2,776,279,800.00	2,469,524,678.70	306,755,121.30	89.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	758,797,000.00	684,417,026.04	74,379,973.96	90.2
210104	Урамшуулал	212,764,300.00	135,252,902.51	77,511,397.49	63.6
210105	Гэрээт ажлын хөлс	48,701,900.00	41,360,158.00	7,341,742.00	84.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,845,356,500.00	1,715,136,703.11	130,219,796.89	92.9
210201	Тэтгэврийн даатгал	1,277,040,600.00	1,171,121,423.12	105,919,176.88	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	137,477,700.00	128,843,610.84	8,634,089.16	93.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	127,948,100.00	135,610,920.00	-7,662,820.00	106.0
210204	Ажилгүйдлийн даатгал	27,513,500.00	24,805,270.56	2,708,229.44	90.2
210205	Эрүүл мэндийн даатгал	275,376,600.00	254,755,478.59	20,621,121.41	92.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	637,849,900.00	624,656,591.58	13,193,308.42	97.9
210301	Гэрэл, цахилгаан	180,496,100.00	176,142,004.80	4,354,095.20	97.6
210302	Түлш, халаалт	355,975,700.00	351,580,201.53	4,395,498.47	98.8
210303	Цэвэр, бохир ус	33,151,800.00	29,389,489.25	3,762,310.75	88.7
210304	Байрны түрээс	68,226,300.00	67,544,896.00	681,404.00	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	579,015,200.00	569,176,546.38	9,838,653.62	98.3
210401	Бичиг хэрэг	135,869,600.00	133,512,780.00	2,356,820.00	98.3
210402	Тээвэр, шатахуун	274,994,500.00	274,190,896.44	803,603.56	99.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	116,150,200.00	110,326,815.94	5,823,384.06	95.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,270,700.00	2,048,900.00	221,800.00	90.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,730,200.00	49,097,154.00	633,046.00	98.7
2105	Нормативт зардал	15,099,904,100.00	15,097,892,489.49	2,011,610.51	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,051,979,700.00	15,050,070,929.49	1,908,770.51	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	47,924,400.00	47,821,560.00	102,840.00	99.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	664,980,300.00	537,522,450.00	127,457,850.00	80.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	389,191,700.00	289,080,710.00	100,110,990.00	74.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	27,336,300.00	27,027,750.00	308,550.00	98.9

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210604	Урсгал засвар	248,452,300.00	221,413,990.00	27,038,310.00	89.1
2107	Томилолт, зочны зардал	161,054,800.00	157,619,345.00	3,435,455.00	97.9
210702	Дотоод албан томилолт	161,054,800.00	157,619,345.00	3,435,455.00	97.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,380,940,300.00	12,359,756,016.89	21,184,283.11	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,007,137,200.00	11,991,527,254.45	15,609,945.55	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,110,000.00	14,959,369.00	1,150,631.00	92.9
210803	Даатгалын үйлчилгээ	24,086,300.00	22,840,963.00	1,245,337.00	94.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	10,898,200.00	10,211,187.00	687,013.00	93.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	5,074,500.00	4,405,192.00	669,308.00	86.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	310,789,400.00	309,398,360.44	1,391,039.56	99.6
210807	Газрын төлбөр	6,844,700.00	6,413,691.00	431,009.00	93.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,232,200.00	125,761,245.34	470,954.66	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	122,904,100.00	122,433,155.34	470,944.66	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,328,100.00	3,328,090.00	10.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	617,246,800.00	517,846,691.60	99,400,108.40	83.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	617,246,800.00	517,846,691.60	99,400,108.40	83.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,836,000.00	25,816,684.00	19,316.00	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	540,300,700.00	442,623,537.60	97,677,162.40	81.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,110,100.00	49,406,470.00	1,703,630.00	96.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,903,981,500.00	44,346,010,469.19	1,557,971,030.81	96.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44,975,035,600.00	43,424,196,348.39	1,550,839,251.61	96.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	44,975,035,600.00	43,424,196,348.39	1,550,839,251.61	96.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	928,945,900.00	921,814,120.80	7,131,779.20	99.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	928,945,900.00	921,814,120.80	7,131,779.20	99.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,507.00	2,461	46	98.2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,252.00	1,229	23	98.2
620001	Удирдах ажилтан	26	25	1	96.2
620002	Гүйцэтгэх ажилтан	1,134.00	1,114	20	98.2
620003	Үйлчлэх ажилтан	92	90	2	97.8

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		17,405,170,334.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ		17,367,716,918.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		17,229,800,712.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		20,240,043.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт		4,079,425.00
210105	Гэрээт ажлын хөлс		16,160,618.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,776,046.00
210301	Гэрэл, цахилгаан		252,623.00
210302	Түлш, халаалт		9,523,423.00
2104	Хангамж, бараа материалын зардал		246,003,221.00
210401	Бичиг хэрэг		19,445,570.00
210402	Тээвэр, шатахуун		195,534,457.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,540,000.00
210404	Ном, хэвлэл		7,992,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		21,490,694.00
2105	Нормативт зардал		4,950,238,687.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		4,926,712,187.00
210502	Хоол, хүнс		2,814,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		20,712,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		337,543,930.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		233,288,576.00
210602	Тавилга		10,171,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		15,606,000.00
210604	Урсгал засвар		78,478,154.00
2107	Томилолт, зочны зардал		232,573,299.00
210702	Дотоод албан томилолт		232,573,299.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,457,673,636.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,457,673,636.06
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		975,751,849.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		971,291,849.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,460,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		137,916,205.62
2132	Бусад урсгал шилжүүлэг		17,984,712.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		17,984,712.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		119,931,493.62
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		119,931,493.62
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		37,453,416.00
2200	Дотоод эх үүсвэрээр		37,453,416.00
220001	Барилга байгууламж		37,453,416.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		17,405,170,424.09
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		17,405,170,424.09
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		695,224,722.89
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,893,946,292.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,969,496,556.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		846,502,852.38
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		90
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		90

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Л.Мөнхцацрал, аудитор Ц.Мөнхтуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/282 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мал эмнэлгийн ерөнхий газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангаж, худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино” гэж тодорхойлсон.

Мал эмнэлгийн ерөнхий газар нь Мал амьтны эрүүл мэндийн тухай, Төрийн албаны тухай хуулиуд болон түүнийг дагалдан гарсан заавар, журам, “Төрөөс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын дагуу мал, амьтны болон нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мал эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг сайжруулах, малын өвчин эмгэгтэй тэмцэх, хүн ам, эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдал, худалдааны чөлөөт байдлыг баталгаажуулах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг.

Дээрх үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх бодлогыг оновчтой төлөвлөж, улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж хэрэгжилтийг зохион байгуулах;
- Мал, амьтны шинэ болон дахин сэргэж буй, уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайгаас шалтгаалсан өвчин эмгэгийн шалтгаан, нөхцөлийг судалж өвчинтэй тэмцэх арга хэмжээг боловсруулах, судалгаа шинжилгээний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Өвчингүй тайван бүсийг тогтоож, мал эмнэлгийн олон улсын гэрээ хэлцэл, ариун цэвэр, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, худалдааны чөлөөт байдлыг дэмжих;
- Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах, баталгаажуулах замаар нийтийн эрүүл мэндийг хамгаалах;
- Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бий болгох, эрт илрүүлэлт, шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн тогтолцоог бүрдүүлж, бүсчлэн хөгжүүлж, чадавхыг дээшлүүлж, үндэсний болон бүс нутгийн лавлагаа лабораторийн түвшинд хүрэх;

- Мал, амьтны эмийн үндэсний үйлдвэрлэлийн шинэчлэл хийж, олон улсын жишигт нийцүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн үлдэгдлийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, эмийн худалдаа, үйлчилгээний бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх;
- Мал эмнэлгийн гадаад харилцааг өргөжүүлэх, мал эмнэлгийн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангуулах;
- Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор эрсдэлд суурилсан, мэргэшсэн, чадварлаг мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- Мал эмнэлгийн салбарын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, дотоод, гадаадын сайн туршлагыг нэвтрүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
- Мал эмнэлгийн салбар байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангаж, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын төрийн захиргааны удирдлагын менежментийг төлөвшүүлж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-г нэвтрүүлэх зэрэг болно

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аас 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт сул байна.

Харьяа байгууллагуудын дотоод шилжүүлэг, бүртгэл тооцоонд тавих хяналт үр нөлөөтэй боловч агентлагийн дотоод аудитор тогтвор суурьшилгүй, салбар байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн материаллаг байгаа нь дотоод хяналтын үр нөлөөг сул гэж дүгнэхэд хүргэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын Төрийн захиргаа, санхүү, удирдлагын газрын санхүүгийн дотоод аудитор аймгуудын шилэн дансны хөтлөлтөд хяналт тавьж, аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “өндөр” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлого 62,774.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 941.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, хувь хэмжээг өөрчлөлгүй, 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлого 60,797.5 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 912.0 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Тайлант оны нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар 57,266.0 сая төгрөгийн мөнгөн орлого төвлөрч, үйл ажиллагаанд 56,344.2 сая төгрөг, хөрөнгө оруулалтад 549.4 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл				/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	
Касст байгаа бэлэн мөнгө	0.0	0.0	0.0	
Дүн	0.0	0.0	0.0	

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мал эмнэлгийн ерөнхий газар мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 90 төгрөгөөр тайлагнасан нь жижиг мөнгөн сангийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн анхан шатны болон е-баримтгүй ажил, гүйлгээг бүртгэлд тусгасан /БүМЭГ 0.2 сая, ГаМЭГ 3.8 сая, ДаМЭГ 0.4 сая, ДоМЭГ 0.8 сая, СбМЭГ 5.4 сая, ТАМЭГ 756.0 сая, НМЭГ 18.8 сая/
- Хууль бусаар ажлаас халагдсан нөхөн олговрыг буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй /УМЭАЦТЛ 9.3 сая/
- Шүүхийн шийдвэртэй холбоотой болзошгүй өр төлбөр 5.5 сая төгрөг байна /МЭЕГ/
- Гэрээт ажлын хөлснөөс НДШ, ХХОАТ суутгаагүй НМЭГ-1.3 сая төгрөг байна.
- Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж, зардал гаргасан /МЭЕГ-20.8 сая, ГаМЭГ-0.9 сая, ГсМЭГ-0.6 сая, ДаМЭГ-0.1 сая, ДоМЭГ-3.1 сая, ДаМЭГ-1.2 сая, ХоМЭГ-11.3 сая, ХөМЭГ-16.5 сая, МЭЭСБҮЛ 3.3 сая/
- Тандалтын төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээнд зардал зарцуулсан МЭЕГ-41.4 сая,
- Төсвийн хэмнэлт бий болгоогүй, үр ашиггүй зардал гаргасан /ЗаМЭГ-0.3 сая, ӨвМЭГ-0.4 сая, ӨгМЭГ-0.7 сая, МЭЭСБҮЛ-1.8 сая, ДүМЭГ-92.4 сая/

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 1,135.5 сая төгрөг болж, 323.7 сая төгрөгөөр өссөн нь шүлхийн вакцины худалдан авах гэрээний урьдчилгаа төлбөрийг оны эцэст шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	8,636.6	1,910.7	(6,725.9)
Төлбөртэй үйлчилгээний авлага	44,133.6	21,519.6	(22,614.0)
Татаас, санхүүжилтийн авлага	612,628.3	77,176.7	(535,451.6)
Бусад авлага	146,417.7	1,034,851.0	888,433.3
Дүн	811,816.2	1,135,458.0	323,641.8

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд дараах байгууллагуудын татаас санхүүжилтийн болон байгууллага, хувь хүнээс авах авлага нэмэгдсэн байна. Тухайлбал:

- Нийслэлийн МЭГ 1.9 сая төгрөгийн ажилчдаас авах,
- Дорноговь аймгийн МЭГ 10.1 сая төгрөгийн татаас санхүүжилтийн,
- УМЭАЦТЛ 39.9 сая төгрөгийн татаас санхүүжилтийн,
- Мал эмнэлгийн ерөнхий газар 27.7 сая төгрөгийн татаас санхүүжилтийн,
- Мал эмнэлгийн ерөнхий газар 984.7 сая төгрөгийн байгууллагаас авах,
- Баянхонгор аймгийн МЭГ 1.1 сая төгрөгийг байгууллагаас авах,
- Хөвсгөл аймгийн МЭГ 30.0 сая төгрөг байгууллагаас авах авлага.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 11.7 сая төгрөгийн дараах авлага байна. Тухайлбал:

- Нийслэлийн мал эмнэлгийн газар 1.9 сая төгрөгийн хувь хүнээс авах авлага,
- Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газар 9.8 сая төгрөгийн хувь хүнээс авах авлага.

Аудитын илрүүлэлт:

- Авлага барагдуулах арга хэмжээ аваагүй /ХөМЭГ 30.0 сая, НМЭГ 1.9 сая/;
- Төсвийн төлөвлөлтийн программ худалдан авч, авлага үүсгэсэн /ГамЭГ 7.2 сая, ОрМЭГ 7.2 сая, ГсМЭГ/

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 179.1 сая төгрөг болж, 95.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	83,808.4	179,150.0	95,341.6
Дүн	83,808.4	179,150.0	95,341.6

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 95.3 сая төгрөгөөр өссөн нь харьяа байгууллагууд мал эмнэлгийн нэгдсэн системийн мэдээлэл технологийн “Open gov” системийн үйлчилгээний хөлсийг урьдчилж төлснөөс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс дараа оны мэдээлэл технологийн үйлчилгээний хөлсөнд 20.8 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэн-МЭЕГ

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 9,600.2 сая төгрөг болж, 1,388.2 сая төгрөгөөр буурсан нь эм боох материал болон тусгай зориулалтын материалын зарцуулалттай холбоотой байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	2,004,054.7	1,282,479.4	(721,575.3)
Эм боох материал	5,603,885.5	4,580,087.2	(1,023,798.3)
Бичиг хэргийн материал	124,410.1	134,209.4	9,799.3
Аж ахуйн материал	755,280.7	671,968.3	(83,312.4)
Сэлбэг хэрэгсэл	42,142.8	35,766.8	(6,376.0)
Түлш, шатах тослох материал	69,821.6	88,488.7	18,667.1
Барилгын засварын материал	32,396.8	32,918.8	522.0
Хүнсний материал	58.3	233.1	174.8
Бусад хангамжийн материал	2,271,420.1	2,672,835.2	401,415.1
Мал амьтад	84,904.6	101,241.9	16,337.3
Дүн	10,988,375.2	9,600,228.9	(1,388,146.3)

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал 37,133.5 сая төгрөгөөр нэмэгдсэн /худалдан авсан 16,445.7 сая, шилжүүлж авсан 15,884.3 сая, хандиваар 4,803.5 сая/, 38,521.6 сая төгрөгөөр буурсан /зарцуулсан 23,228.9 сая, балансаас балансад шилжүүлсэн 14,023.3 сая, бүтцийн өөрчлөлтөөр бусад байгууллагад шилжүүлсэн 1,269.4 сая/ байна.

Малын гоц халдварт шүлхий өвчний тархалт нэмэгдсэнтэй холбоотой вакцины нөөцийг бүрэн дайчилж, эмнэлгийн халдвар, хамгааллын бодисын зарцуулалт нэмэгдсэнээс тусгай зориулалтын материал 721.6 сая төгрөг, эм боох материал 1,023.8 сая төгрөгөөр буурсан нь дансны өөрчлөлтөд голлох нөлөө үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Хөрөнгийн эдийн засгийн ангилал зөрчиж, БМ-ын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн-МЭЭГ 21.2 сая төгрөг.
- Эргэц багатай бараа материал нөөцөнд байна /МЭЭГ-43.2 сая, МЭЭСБҮЛ-0.7 сая/
- Вакцины эргэцэд тавих дотоод хяналт сул, хугацаа дууссан /МЭЭГ-114.4 сая, ДаМЭГ 0.1 сая, ОрМЭГ-111.7 сая, ХоМЭГ, ГаМЭГ-17.4 сая/
- Малын нас дэвшилт хийгээгүй-БхМЭГ-1.0 сая, баримтын бүрдэл хангалтгүй /БхМЭГ-15.5 сая, СэМЭГ 2.2 сая/
- Өмнөх онд зарцуулсан бараа материалыг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн-УМЭАЦТЛ 957.9 сая төгрөг байна.
- Хэрэгцээнээс илүү бараа материал нөөцөлсөн /МЭЭСБҮЛ 2.5 сая, ОрМЭГ 0.5 сая/
- Шатахууны баримтгүй, замын хуудасгүй, шатахууны урамшууллыг бүртгээгүй /БүМЭГ 0.4 сая, ГаМЭГ-0.3 сая, ОрМЭГ 11.1 сая/
- Үнэ төлбөргүй хүлээн авсан болон төсвөөс бэлтгэсэн бараа материалыг бүртгэлд тусгаагүй ХоМЭГ-2.2 сая, ашиглалтад байгаа нормын хувцсыг зардлаар бүртгэсэн МЭЭСБҮЛ-4.1 сая

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 26,493.4 сая төгрөг болж, 168.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	24,170,110.2	24,048,201.7	(121,908.5)
Барилга, байгууламж, орон сууц	11,997,237.6	12,244,499.6	247,262.0
Хуримтлагдсан элэгдэл	(756,016.4)	(1,175,101.2)	419,084.8
Авто-тээврийн хэрэгсэл	8,154,069.2	8,278,757.8	124,688.6
Хуримтлагдсан элэгдэл	(4,985,693.8)	(5,289,087.2)	303,393.4
Машин тоног төхөөрөмж	13,246,276.8	15,535,925.2	2,289,648.4
Хуримтлагдсан элэгдэл	(7,669,419.6)	(9,001,436.4)	(1,332,016.8)
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,282,414.8	2,232,755.5	(49,659.3)
Хуримтлагдсан элэгдэл	(1,095,109.1)	(1,230,559.0)	(135,449.9)
Бусад үндсэн хөрөнгө	7,885,296.5	6,885,013.9	(1,000,282.6)
Хуримтлагдсан элэгдэл	(4,901,932.4)	(4,445,553.2)	(456,379.2)
Дуусаагүй барилга	12,986.6	12,986.6	0.00
Биет бус хөрөнгө	2,154,337.2	2,445,174.1	290.836.9
Программ хангамж	180,018.0	265,293.0	85,275.0
Хуримтлагдсан элэгдэл	(34,905.6)	(60,962.9)	(26,057.3)
Бусад биет бус хөрөнгө	2,012,192.6	2,242,382.6	230,190.0
Хуримтлагдсан элэгдэл	(2,967.8)	(1,538.5)	1,429.3
Дүн	26,324,447.4	26,493,375.8	168,928.4

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгийн 23.1 хувь буюу 5,939.2 сая төгрөг нь Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори, 9.2 хувь буюу 2,360.4 сая төгрөг нь Өмнөговь аймгийн МЭГ, 6.7 хувь буюу 1,717.8 сая төгрөг нь Нийслэлийн Мал эмнэлгийн газар, 14,004.8 сая төгрөг нь бусад нэгжүүдийн балансад бүртгэлтэй байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 4,723.6 сая төгрөгөөр нэмэгдэж /шилжүүлэн авсан 2,574.2 сая, хандиваар 1,541.1 сая төгрөг, худалдан авсан 512.0 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 96.3 сая/, 4,554.6 сая төгрөгөөр буурсан /акталсан 1,332.5 сая, балансаас балансад шилжүүлсэн 1,075.3 сая, дахин үнэлгээний хорогдол 388.7 сая, элэгдлийн зардал 1,758.1 сая/ байна.

Аудитын илрүүлэлт:

- МЭЭГ 11.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг илүү тайлагнасан,
- Төсвийн хэмнэлтээс хөрөнгө бэлтгэсэн ЗаМЭГ-2.9 сая,
- Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж хөрөнгө бэлтгэсэн ӨвМЭГ-4.4 сая,
- Хөрөнгийн ангилал зөрчиж, бараа материалын дансанд бүртгэсэн НМЭГ 2.7 сая төгрөг

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 53.9 сая төгрөг болж, 1,638.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	6,796.5	376.3	(6,420.2)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	15,617.3	9,180.9	(6,436.4)
Байгууллагад төлөх өглөг	1,655,627.9	44,155.9	(1,611,472.0)
Хувь хүмүүст төлөх өглөг	14,214.7	166.1	(14,048.6)
Дүн	1,692,256.4	53,879.2	(1,638,377.2)

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацааны өглөг буурахад Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвөөс урд онд үүссэн мал эмнэлгийн хувийн үйлчилгээний нэгжүүдэд олгох гоц халдварт өвчний вакцины тарилгын үйлчилгээний өр төлбөр 1,650.7 сая төгрөгийг барагдуулсан нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн МЭЭСБҮЛ -3.4 сая,
- Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг буруу дүгнэж зөрүү үүсгэсэн МЭЭСБҮЛ- 19.8 сая,
- Төсөвт учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй УМЭАЦТЛ-7.3 сая

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 37,354.3 сая төгрөг болж, 838.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	9,281,790.5	9,348,990.5	67,200.0
Хуримтлагдсан үр дүн	23,122,784.7	23,893,727.3	770,942.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,111,615.5	4,111,615.5	0.0
Дүн	36,516,190.7	37,354,333.3	838,142.6

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант оны үр дүн 770.9 сая төгрөг, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 67.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 76,500.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг Улсын Их хурлаар 24,105.5 сая төгрөгөөр бууруулж 52,394.6 сая төгрөгөөр баталсан байна. Тайлант жилийн дундуур батлагдсан төсөвт тодотгол хийж, төсвийг 6,490.6 сая төгрөгөөр дахин бууруулж 45,904.0 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Засгийн газар төсвийн хэмнэлтийн горимыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 45,904.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, 44,975.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 928.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 43,424.2 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлого 921.8 сая, нийт 44,346.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 43,828.2 сая төгрөгийг зарцуулж, 517.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 928.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 921.8 сая төгрөг бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 7.1 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн нь Сангийн Яамнаас УМЭАЦТЛ-ийн орлогын төлөвлөгөөг тодотголоор нэмэгдүүлж баталсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 44,346.0 сая төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь сумдын малын эмч, тархвар зүйч нарын орон тоо дутуу ажиллаж, цалин хөлс, нийгмийн даатгалын зардал хэмнэсээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 695.2 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 9,893.9 сая, дээд шатны төсвийн захирагчаас 5,969.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 846.5 сая, нийт 17,405.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн 17,285.2 сая төгрөгийг зарцуулж, 119.9 сая төгрөгийг улсын төсвийн орлогын дансанд татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 32 зорилт бүхий нийт 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээс бодлогын 44 бичиг баримт, төрийн 38 төрлийн үйлчилгээ, 6 тусгай чиг үүргийн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 94.9 хувьтай хэрэгжсэн бөгөөд 58 арга хэмжээ 100 хувь, 5 арга хэмжээ 90 хувь, 9 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй байв.

Хүн болон мал эмнэлгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, Зооноз өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах хамтарсан зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх, Зооноз өвчнийг хяналтад авах стратеги төлөвлөгөөг хамтран боловсруулах, батлуулах хөтөлбөрийн хэрэгжилт 50 хувьтай биелсэн нь Эрүүл мэндийн яамнаас Ковид-19 цар тахалтай тэмцэж буй нөхцөл, байдлаас шалтгаалан хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжгүй болсноос шалтгаалжээ.

3.8 Аудитын гол асуудал

2021 оны хавраас эхлэн улсын хэмжээнд шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах зэрэг олон улсын худалдааны хөл хориот, вирусээр үүсгэгддэг мал, амьтны гоц халдварт өвчнүүд бүртгэгдэж, уг өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг холбогдох заавар, журмын дагуу хэрэгжүүлэн ажилласнаас бог малын мялзан, хонины цэцэг өвчнүүдийг бүрэн хяналтад авсан байна.

Гоц халдварт шүлхий өвчний гаралт нэмэгдэж, оны эцсийн байдлаар 267 голомтод 147,337 толгой мал, амьтан өвчилж, улсын хэмжээнд халдвар өргөн тархсан нь голомтыг цомхотгох, өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд агентлагийн санхүү болоод хүний нөөцийн чадавх хүрэлцэхгүй нөхцөл үүссэн нь салбарын хэмжээний анхаарал татах чухал асуудал болж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг харьяа 25 нэгжид хийсэн аудитын дүнгээс нэгтгэхэд нийт 485.6 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрч, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэлээ.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар нийцлийн аудитын 1,817.4 сая төгрөгийн 17 зөрчил илэрснээс 1,790.3 сая төгрөгийн 10 зөрчилд албан шаардлага, 9.6 сая төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгч, 17.5 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан 1,280.0 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулсан боловч хэрэгжүүлээгүй /МЭЭГ/, Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэлгүй 8.2 сая төгрөгийн худалдан авалт хийсэн /АМЭГ/.
- Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй нийт 485.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн /Говьсүмбэр аймгийн МЭГ 129.4 сая, НМЭГ 347.0 сая, УМЭАЦТЛ 9.3 сая төгрөг/
- Төсвийн хэмнэлт үүсгээгүй 16.5 сая төгрөг НМЭГ, нэмэлт санхүүжилтийн төсвөөс урсгал үйл ажиллагаанд 9.6 сая төгрөгийн зардал зарцуулсан Өмнөговь аймгийн МЭГ/

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 2,717.8 сая төгрөгийн 5 зөвлөмж, 1.5 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилт
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	5	2,717,800.0	5	2,717,800.0	-	-	100
Албан шаардлага	2	1,500.0	2	1,500.0	-	-	100
Нийт	7	2,719,500.0	7	2,719,300.0	-	-	100

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Малын тоо толгой, өвчлөлийн тархвар зүйд үндэслэн вакциныг үр дүнтэй зарцуулсан эсэх, мал эмнэлгийн эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг үнэн зөв тооцоолж, салбарын хэмжээнд вакцины нөөцийн норм, тоо хэмжээг бүрдүүлж ажилласан эсэхэд нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлнэ.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 4,668.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,850.8 сая төгрөг буюу 61 хувь нь санхүүгийн аудитын, 1,817.4 сая төгрөг буюу 39 хувь нь нийцлийн аудитын асуудал байна.

Аудитаар 2,850.8 сая төгрөгийн 113 алдаа, зөрчил илэрснээс, 509.3 сая төгрөгийн 36 алдааг залруулж, 16.7 сая төгрөгийн 11 төлбөрийн акт тогтоож, 2,103.3 сая төгрөгийн 28 албан шаардлага хүргүүлж, 221.5 төгрөгийн алдаа, зөрчилд 38 зөвлөмж хүргүүллээ.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 2,341.6 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 912.0 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 25 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэн аудитад хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 22 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори, Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори, Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн өмнөх оноос 5,761.1 сая төгрөгөөр буурсан боловч Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд санхүүгийн аудитын залруулагдаагүй алдаа зөрчил 2,341.6 сая төгрөг, нийцлийн аудитын 1,817.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн, “хязгаарлалттай” дүгнэлт авсан харьяа байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаанд анхаарч ажиллах шаардлагатай байна.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Цахим Е-тайлангийн системийн тохиргооны алдаанаас үүдсэн дараах зөрүүг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл 28,600.2 сая төгрөг, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл 7,007.2 сая төгрөгөөр тус тус өмнөх оны аудит хийсэн нэгтгэсэн тайлангийн дүнгээс зөрүүтэй;
- Санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын дансны үлдэгдэл тодруулга тайлангийн дүнгээс 618.1 сая төгрөг, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл тодруулга тайлангийн дүнгээс 765.7 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй алдаа.

4.2.2 Албан шаардлага

1. Мал амьтны гоц халдварт өвчний гаралтын тоо 2016, 2017, 2021 онуудад огцом өсөлттэй, сүүлийн 5 жилийн байдлаар богийн мялзан өвчин, хонины цэцэг, гахайн африкийн мялзан, үхрийн арьс товруутах өвчин шинээр бүртгэгдэж, өвчилсөн малын тоо буураагүй байна. Үүн дотроо шүлхий өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээнд 2019-2021 онд 21,5 сая толгой малыг хамруулж, 43.408.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан хэдий ч 2021 оны жилийн эцсийн байдлаар 20 аймгийн 170 сумын 147,337 тоо толгой мал өвчилсөн нь Мал эмнэлгийн ерөнхий газрын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ оновчгүй, үр нөлөөгүй байгааг харуулж байна.

Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Агентлаг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтлан ажиллана”, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ улс, бүс, нутгаар хязгаарлалт тогтоох бодлого баримтална”, 13 дугаар зүйлийн 13.2 “Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага халдварт өвчний онош батлагдсан даруйд бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу мал эмнэлгийн бүх шатны байгууллагыг мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хяналт тавьж ажиллана”, 15 дугаар зүйлийн 15.9.2 “гоц халдварт өвчний оношилгооны дүгнэлт, тархвар зүйн судалгаанд тулгуурлан тухайн өвчний голомтыг цомхотгох, устгах хариу арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.6 “Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг товлосон хугацаанд хэрэгжүүлээгүй, эсхүл мал эмнэлгийн үйлчилгээний заавар, стандартыг мөрдөж ажиллаагүйн улмаас бусдад учирсан хохирлыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

2. Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа 25 нэгжийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 2,341.6 сая төгрөгийн санхүүгийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой материаллаг хэмжээний алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37 “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 5 дугаар зүйлийн 5.1 Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; 6 дугаар зүйлийн 6.6.1 “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т “Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт			Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
			Үүнээс					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	1	1		11	367,942.3	1	79,585.0	0	-	2	178,731.1	8	109,626.2
2	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	БНА-2022/185/НА-СТА-ТШЗ	1	1		4	16,520.5					2	985.0	2	15,535.5
3	Булган аймгийн Мал эмнэлгийн газар	БУА-2022/164/НА/СТА-ТШЗ	1	1		3	545.0					1		2	545.0
4	Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газар	ГАА-2022/74/НА-СТА-ТШЗ	1	1		5	29559.4			1	256.2	4	29,303.2		
5	Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газар	ГСА-2022/64/СТА-ТШЗ	1	1		8	4,925.8	5	2,591.6			2	585.2	1	1,749.0
6	Дархан аймгийн Мал эмнэлгийн газар	ДАА-2022/148/НА-СА-ТШЗ	1	1		3	239.2			2	239.2			1	
7	Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар	ДГА-2022/153/НА-СТА-ТШЗ	1	1		10	104,608.0	7	103,900.0	1	408.0			2	300.0
8	Дорнод аймгийн Мал эмнэлгийн газар	ДОА-2022/173/НА/СТА-ТШЗ	1	1		2	3,854.8					2	3,854.8		
9	Дундговь аймгийн Мал эмнэлгийн газар	ДУА-2022/15/НА-СТА-ТШЗ	1	1		5	26,994.9	3	25,731.7	2	1,263.2				
10	Завхан аймгийн Мал эмнэлгийн газар	ЗАА-2022/58/СТА-ТШЗ	1	1		3	8207.7	1	4996.3	1	311.7	1	2899.7		
11	Орхон аймгийн Мал эмнэлгийн газар	ОРА-2022/32/НА-СТА-ТШЗ	1		1	4	130,499.8					1	111,662.0	3	18,837.8
12	Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн газар	ӨВА-2022/79/НА-СТА-ТШЗ	1	1		2	4,769.6					2	4,769.6		
13	Өмнөговь аймгийн Мал эмнэлгийн газар	ӨМА-2022/167/НА-СТА-ТШЗ	1	1		6	2,220.5	4	1,483.4			1	737.1	1	
14	Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газар	СБА-2022/30/НА-СТА-ТШЗ	1	1		2	5,440.0					1	5,440.0	1	
15	Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газар	СЭА-2022/261-НА-СТА-ТШЗ	1	1		2	2,225.3							2	2,225.3
16	Төв аймгийн Мал эмнэлгийн газар	ТӨА-2022/08/-НА-СТА-ТШЗ	1	1		5	803,814.3	3	47,815.3			1	755,999.0	1	
17	Увс аймгийн Мал эмнэлгийн газар	УВА-2022/86/НА-СТА-ТШЗ	1	1		1								1	

18	Ховд аймгийн Мал эмнэлгийн газар	ХОА-2022/07/НА-СТА-ТШЗ	1	1		8	94,391.0	1	80,400.0	1	3,791.0	1		5	10,200.0
19	Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар	ХӨА-2022/237/НА-СТА-ТШЗ	1	1		4	95,500.0	1	49,000.0					3	46,500.0
20	Нийслэлийн аймгийн Мал эмнэлгийн газар	ХАК-2022/104/НА-СА-ТШЗ	1	1		7	29,411.8	2	4,671.8	1	1,340.0	2	14,732.3	2	8,667.7
21	МЭЭСБҮЛ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	1		1	10	52,534.6	2	16,900.6	1	1,841.9	3	26,422.6	4	7,369.5
22	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/НА-СТА-ТШЗ	1		1	9	1,066,633.0	6	92,188.8	1	7,257.2	2	967,187.0		
23	Архангай аймгийн Мал эмнэлгийн газар	АРА-2022/37/НА-СТА-ТШЗ	1	1											
24	Баян-Өлгий аймгийн Мал эмнэлгийн газар	БӨА-2022/181/НА-СТА-ТШЗ	1	1											
25	Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газар	ХЭА-2022/17/НА-СТА-ТШЗ	1	1											
Дүн			25	22	3	114	2,850,837.5	36	509,264.5	11	16,708.4	28	2,103,308.6	39	221,556.0

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс					
					Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	2	1,280,000.0			2	1,280,000		
2	Архангай аймгийн мал эмнэлгийн газар	АРА-2022/37/НА-СТА-ТШЗ	3	8,200.0			3	8,200.0		
3	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	БНА-2022/185/НА-СТА-ТШЗ	1				1			
4	Булган аймгийн МЭГ	БУА-2022/164/НА-СТА-ТШЗ	1				1			
5	Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газар	ГСА-2022/64/СТА-ТШЗ	1	129,436.5			1	129,436.5		
6	Дорнод аймгийн Мал эмнэлгийн газар	ДОА-2022/173/НА-СТА-ТШЗ	1						1	
7	Дундговь аймгийн Мал эмнэлгийн газар	ДУА-2022/15/НА-СТА-ТШЗ	1						1	
8	Өмнөговь аймгийн Мал эмнэлгийн газар	ӨМА-2022/167/НА-СТА-ТШЗ	2	9,560.0					2	9,560.0
9	Нийслэлийн аймгийн Мал эмнэлгийн газар	ХАК-2022/104/НА-СА-ТШЗ	2	363,417.9			2	363,417.9		
10	МЭЭСБҮЛ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	1				1			
11	УМЭАЦТЛ	АХГ-2022/346/НА-СТА-ТШЗ	1	9,258.9			1	9,258.9		
12	Дархан-Уул аймгийн Мал эмнэлгийн газар	ДАА-2022/148/НА-СА-ТШЗ	1	17,514.8	1	17,514.8				
Дүн			17	1,817,388.1	1	17,514.8	12	1,790,313.3	4	9,560.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 701/АО160073

Улаанбаатар хот

АХГ-2022/19/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа 25 нэгжийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 2,341,600,000.0 төгрөгийн санхүүгийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой материаллаг хэмжээний алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37 "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6.1 "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Алдаа, зөрчил гаргасан харьяа нэгжүүдийн санхүү, төсвийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод хяналтыг сайжруулахад анхаарч, илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид дээрх зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Батчулуун, ерөнхий нягтлан бодогч Б.Содбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\0.10.10.20\\Richig_Kherog\\Alban Shaardlaga\\2022\\0315 Auditin 2 Gazar-341.Docx

4006104
5019120396

0001081737



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 702/АО160073

Улаанбаатар хот

АХТ-2022/19/ХА-СТА-ТТЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мал амьтны гоц халдварт өвчний гаралтын тоо 2016, 2017, 2021 онуудад огцом өсөлттэй, сүүлийн 5 жилийн байдлаар бог малын мялзан өвчин, хонины цэцэг, гахайн африкийн мялзан, үхрийн арьс товруудах өвчин шинээр бүртгэгдэж, өвчилсөн малын тоо буураагүй байна. Үүн дотроо шүлхий өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээнд 2019-2021 онд 21.5 сая толгой малыг хамруулж, 43,408,600,000.0 төгрөгийн хөрөнгө зарцуулсан хэдий ч 2021 оны жилийн эцсийн байдлаар 20 аймгийн 170 сумын 147.3 мянган тоо толгой мал өвчилсөн нь Мал эмнэлгийн ерөнхий газрын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ оновчгүй, үр нөлөөгүй байна.

Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Агентлаг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтлан ажиллана", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ улс, бүс, нутгаар хязгаарлалт тогтоох бодлого баримтална", 13 дугаар зүйлийн 13.2 "Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага халдварт өвчний онош батлагдсан даруид бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу мал эмнэлгийн бүх шатны байгууллагыг мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хяналт тавьж ажиллана", 15 дугаар зүйлийн 15.9.2 "гоц халдварт өвчний оношилгооны дүгнэлт, тархвар зүйн судалгаанд тулгуурлан тухайн өвчний голомтыг цомхотгох, устгах хариу арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6 "Малын халдварт, гоц халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг товлосон хугацаанд хэрэгжүүлээгүй, эсхүл мал эмнэлгийн үйлчилгээний заавар, стандартыг мөрдөж ажиллаагүйн улмаас бусдад учирсан хохирлыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Малын гоц халдварт өвчний тархвар зүйн судалгаанд тулгуурлан голомтыг цомхотгох, устгах хариу арга хэмжээг оновчтой удирдан зохион байгуулах, санхүү, төсвийн нөөцийг зохистой хуваарилж, хуулиар хүлээсэн чиг үүргийг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэхэд анхаарч, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Батчулуун, ерөнхий нягтлан бодогч Б.Содбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Л.МӨНХЦАЦРАЛ

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of numerous horizontal rows, each defined by two parallel dotted lines. The rows are evenly spaced and extend across the entire width of the page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.